



Байнгын хорооны 2022 оны 03  
дугаар тогтоолын хоёрдугаар  
хавсралт

### ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

**Товч удирдамж :** Нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн дор /ард/ хариултаа үнэн зөв бичнэ. Компьютерын програм ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралт мөн Word-ын файлыг шуудангаар болон цахимаар тус тус Байнгын хороонд явуулна.

#### НЭГ. НЭР ДЭВШИГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, НИЙТЛЭГ ШААРДЛАГА

1.1	<b>Эцэг/эхийн нэр:</b> Баасан <b>Ургийн овог:</b> Галынхан <b>Нэр:</b> Алтанхуяг <b>Хүйс:</b> Эр <b>Төрсөн он:</b> 1990 <b>Төрсөн газар:</b> Дорноговь аймаг, Иххэт сум, Зүлэгт тосгон <b>Одоо оршин суугаа аймаг/нийслэл, сум/дүүрэг:</b> Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг. /Мэдээлэл гаргагчийн зөвшөөрлөөр/
1.2	<b>Нэр дэвших тухай хүсэлт гаргаж буй албан тушаал</b> <b>Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн гишүүн</b>
1.3	<b>Нэр дэвшүүлсэн албан байгууллага</b> <b>Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо</b>
1.3	<b>Иргэний харьяалал</b> <b>Монгол улс</b>
1.4	<b>Боловсрол</b> <b>Дээд / МУИС-ХЗС эрх зүйч/</b>
1.7	<b>Эрхэлсэн ажил</b> Их, дээд сургууль төгссөнөөс хойш эрхэлсэн ажлыг тодорхойлон бичнэ. Ажилласан байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар жагсаах бөгөөд ажил олгогч /эсхүл, удирдах албан тушаалтан/-ийн нэр, хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ. <ul style="list-style-type: none"><li>- 2023-2019, Монголын төмөр замчдын Үйлдвэрчний эвлэлийн холбоо /МТЗ-чдын ҮЭ-ийн холбоо/ - Дэд дарга</li><li>- 2019-2015, МТЗ-чдын ҮЭ-ийн холбоо - О.Т.Б дэд дарга, эрхзүйч, сургалт хариуцсан мэргэжилтэн,</li><li>- 2015-2013, МТЗ-чдын ҮЭ-ийн холбоо – Хуулийн зөвлөх</li></ul>
1.8	<b>Улс төрийн болон намын удирдах, гүйцэтгэх албан тушаал</b> Сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байсан эсэхийг бичих. <b>Үгүй</b>
1.9	<b>Эрүүгийн хариуцлага</b>

	Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол товч тайлбарыг бичих/ <b>Үгүй</b>
1.10	<b>Яллагдагчаар татагдсан эсэх</b> Яллагдагчаар татагдсан эсэх /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол товч тайлбарыг бичих/. <b>Үгүй</b>
1.11	<b>Сахилгын шийтгэлийн талаар</b> Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж эсхүл огцорч байсан эсэх/тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/. <b>Үгүй</b>
1.12	<b>Төрийн бус байгууллагын гишүүнчлэлийн талаар</b> -Төрийн бус байгууллагад эрхэлж байсан албан тушаал, гүйцэтгэсэн чиг үүрэг, огноог хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичнэ. <b>Үгүй</b>
	<b>Нэр дэвшигч нь хэрэв байгаа бол доор дурдсан мэдээллийг бичнэ</b>  -Өөрийн боловсруулсан, хянасан судалгааны ажил, ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн эмхэтгэл – 2, Ганзам пресс, 2020  -Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.  -сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга замыг бичнэ. Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ. “Нэн түрүүнд ХАБ”-2017 “Ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдлын хандлагыг өөрчлөх шаардлага” илтгэл, эрдэм шинжилгээний ажлын судалгааны тайлан “Нэн түрүүнд ХАБ”-2020 “ХАБЭА, Үйлдвэрчний эвлэлийн байгууллагын оролцоо” илтгэл  -сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө.  <b>Жич:</b> Дээр дурдсан материал тус бүрээс нэгийг хавсаргах бөгөөд боломжтой бол цахимаар үзэх линкийг тусгана. <a href="https://www.arслан.mn/social/health/605324.shtml">https://www.arслан.mn/social/health/605324.shtml</a> <a href="https://drive.google.com/file/d/11bokZTCMwbltPonxr2vp0X3iSeRbVF3C/view">https://drive.google.com/file/d/11bokZTCMwbltPonxr2vp0X3iSeRbVF3C/view</a>

**ХОЁР. ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР**

2.1	<p>Тухайн албан тушаалд томилогдвол хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ /500-1000 үгэнд багтаана/.</p> <p>Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөл дэх даатгуулагчийн олонхийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан байгууллагыг төлөөлж нэр дэвшиж буй Баасангийн Алтанхуяг миний бие нь дор дурдсан үндэслэлээр нэр дэвшихийн зэрэгцээ уг албан тушаалд томилогдвол дараах ажлуудыг санаачлан Үндэсний зөвлөлийн хурлаар дэмжүүлэн хийж хэрэгжүүлнэ. Үүнд:</p> <p><b>Нэр дэвшсэн үндэслэлийн талаар:</b></p> <p>Өнөөдрийн монгол улс дах эрүүл мэндийн даатгалын төрөл, албан журмын даатгалын зарчим /Эв санааны нэгдлийн/, шимтгэлийн хувь хэмжээ, түүнийг төлөх журам нь орчин үеийн, олон улсын стандартад нийцсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авах бодит шаардлагыг хангаж буй эсэх, түүнд мониторинг хийж, даатгуулагчийн эрүүл мэндэд ирээдүйд учирч болох бүхий л эрсдлийг даатгалын сангийн үйл ажиллагаагаар бүрэн хамгаалах тогтолцоог бүрдүүлэх, мөн эрүүл мэндийн даатгалын байгууллагуудын тогтолцоо, үйл ажиллагааг орчин үеийн цахим технологид суурилсан өндөр бүтээмж, үр ашигтай, оновчтой системийг нэвтрүүлэх, хамгийн чухал нь нийт даатгуулагчдын төлсөн шимтгэл, мөнгөн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, зарцуулалтад хяналт тавих, даатгуулагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хараат бус, бие даасан байдлаар ажиллах зорилгоор нэр дэвшсэн болно.</p> <p><b>Хийх ажлын талаар:</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Эрүүл мэндийн даатгалын мөнгөн хөрөнгө төвлөрүүлэлтийг нэмэгдүүлэх нөлөөллийн ажлыг цахимаар зохион байгуулах талаар эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх,</li> <li>2. Даатгуулагчдыг эрүүл мэндийн тусламж үйлчилгээ зайлшгүй авах эрсдэлийг бууруулах зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэгийн чанар хүртээмж, нийт даатгуулагчдын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх нөлөөллийн цахим болон үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргаж, түүний хэрэгжилтийг эрүүл мэндийн даатгалын байгууллагаар дамжуулан гүйцэтгүүлэх,</li> <li>3. Даатгалын байгууллагуудын үйл ажиллагааг цахимжуулах үйл ажиллагааг эрчимжүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх, түргэн шуурхай, үр ашигтай ажиллах нөхцлийг бүрдүүлэхэд санал санаачилга, хяналтыг хэрэгжүүлж ажиллах,</li> <li>4. Даатгуулагч өвчилсөн, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авах зайлшгүй шаардлага бий болсон тохиолдолд олон улсын стандартад нийцсэн үйлчилгээг монголдоо авах нөхцөлийг бүрдүүлэх, өндөр төлбөртэй, гадаад улс оронд хийгддэг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төлбөрийн эрсдэлийг давхар даатгалд хамруулах, гадаад орон руу явж буй валютын урсгалыг багасгах,</li> <li>5. Даатгуулагчдын даатгалын мөнгөн хөрөнгийн захиран зарцуулалтыг хууль тогтоомж, үнэт зүйл, ёс суртахууны үзэл баримтлалуудыг удирдлага болгон шийдвэр гаргаж, зөвлөлийн гишүүдийн хараат бус, бие даасан, хяналтын, үр ашигтай ажиллах нөхцлийг бүрдүүлсэн дүрэм журам боловсруулан, санал гаргаж, батлуулан ажиллах,</li> <li>6. Эрүүл мэндийн даатгалын сангийн авлага барагдуулах, орлого зарлагын менежментийг сайжруулах, санхүүгийн үзүүлэлт, үр дүнг сайжруулах талаар олон улсын туршлагад суурилж холбогдох саналыг гарган, хэрэгжүүлж ажиллах</li> </ol>
-----	---

**Хавсралт:**

Холбогдох хуульд заасан шаардлагыг хангасныг нотлох дараах болон бусад баримт бичгийг нэр дэвших тухай хүсэлтэд хавсаргана:


- Төрийн албан хаагчийн анкет;
- Боловсролын зэргийн дипломын хуулбар;
- Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг
- Эрх бүхий байгууллагаас нэр дэвшүүлсэн албан бичиг, шийдвэр

**Хүсэлт гаргагч:**

Эцэг/эхийн нэр: Баасан

Өөрийн нэр: Алтанхуяа

Гарын үсэг:



Он, сар, өдөр: 2022 оны 03 дугаар сарын 16нд

--- оОо ---